



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
СҮМБЭР СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/57

Сүмбэр сум

Мэдээллийн ил тод байдлыг хангах арга
хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалт 58 дугаар зүйлийн 58.4.11 дэх заалт, Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоол, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 09 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Мэдээллийн ил тод байдлыг хангах” арга хэмжээний зардлын 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж иргэдэд мэдээлэл хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангах ажлыг үр дүнтэй зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Б.Хатантөмөр/-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж хэрэгжилтийг тайлагнахыг Сумын Засаг даргын орлогч /Н.Хишигдорж/-д даалгасугай.

ДАРГА



П.АМАРСАЙХАН

Сумын Засаг даргын 2019 оны
сарын 19 өдрийн 09 дугаар
 захирамжийн хавсралт



МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ 2019 ОНД ХАНГАЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажил	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Хүрэх үр дүн	Хариуцах эзэн
1	2	3	4	5	6
1	Багийн хэсгийн ахлагч ажиллуулах	1.1 Орон нутгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх иргэдэд мэдээ мэдээлэл хүргэх, олон нийтийн арга хэмжээний зар түгээх	4 800 000	Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, тогтоомжийн дагуу	Засаг даргын Тамгын газар
2	Мессеж үйлчилгээ	2.1 Сумын нийт өрхийг хамарсан мессеж үйлчилгээ явуулах	300 000	иргэдэд мэдээ мэдээллийн цаг алдалгүй хүрсэн байна.	
3	Засаг даргын Тамгын газар болон орон нутат явагдаж байгаа үйл ажиллагааг олон нийтэтэд мэдээллэх	3.1 Телевизийн мэдээ нэвтрүүлэг, Богино хэмжээний дүрс бичлэг хийх 3.2 Сонин, сэтгүүлд мэдээлэл нийтлэх 3.3 Хэвлэл, гарын авлага, саналын хуудас, мэдээллийн самбараар мэдээллийн иргэдэд хүргэх	4 500 000 1 500 000 2 000 000		
Нийт			13 000 000		



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
СҮМБЭР СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/60

Сүмбэр сум

Багийн хэсгийн ахлагч нарт урамшуулал
олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалын 5 дугаар зүйлийн 5.1 Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 09 дугаар тогтоол, сумын Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/57 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж багийн иргэдэд мэдээлэл хүргэх, олон нийтийн арга хэмжээнд зар түгээж ажиллах 6 хэсгийн ахлагчид улирал тутам урамшуулал олгосугай.
2. Урамшуулалд олгогдохоор батлагдсан 4,800,000 / дөрвөн сая найман зуун мянга/ төгрөгийг сумын Орон нутаг хөгжлийн сангийн “Мэдээллийн ил тод байдлыг хангах” арга хэмжээний зардлаас гаргаж зарцуулахыг нягтлан бодогч /Э.Бямбасүрэн/-д зөвшөөрсүгэй.
3. Баг тус бүр дээр ажиллах хэсгийн ахлагч нартай гэрээ байгуулж удирдлагаар хангаж ажиллахыг багийн Засаг дарга /Н.Идэрзориг, Б.Очирхүү, Т.Гантулга/ нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү захирамжийн биелэлтэнд хяналт тавьж хэрэгжилтийг тайлагнахыг Засаг даргын орлогчид даалгасугай.

ДАРГА

П.АМАРСАЙХАН

